



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 5/38

Хэрлэн сум

Д.Ууганбаярыг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй, албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлага хангасан Даваанямын Ууганбаярыг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн сул орон тоо нөхөгдөх хүртэл хугацаагаар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Д.Ууганбаярын цалинг ТЗ-5-1 шатлалтай адилтган тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР